



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 663

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 170,334,505.00 (нэг зуун далан сая гурван зуун гучин дөрвөн мянга таван зуун таван) төгрөгийн балансын үнэ, 150,462,146.12 (нэг зуун тавин сая дөрвөн зуун жаран хоёр мянга нэг зуун дөчин зургаан төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мэдээллийн Монцамэ агентлагт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр, Мэдээллийн Монцамэ агентлагийн дарга Б.Ганчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлэх, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 457 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 24 ны өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт



**"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, МЭДЭЭЛЛИЙН МОНЦАМЭ АГЕНТЛАГТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузер 200, 00-21 УБЗ, JTMHY7AJ5D014069	170,334,505.00	150,462,146.12	19,872,358.88
		170,334,505.00	150,462,146.12	19,872,358.88
	Нийт дүн	(нэг зуун далан сая гурван зуун гучин дөрвөн мянга таван зуун таван)	(нэг зуун тавин сая дөрвөн зуун жаран хоёр мянга нэг зуун дөчин зургаан төгрөг арван хоёр мөнгө)	(арван есөн сая найман зуун далан хоёр мянга гурван зуун тавин найман төгрөг наян найман мөнгө)